



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/228

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагын албан хаагчдын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах үүднээс албан хэрэгцээнд зориулан аймгийн Засаг даргын баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журмуудын эмхэтгэлийг хэвлүүлэх зардалд 7.000.000 /долоон сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Хөрөнгө зарцуулахад шаардагдах зардлыг Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

011059

Аймгийн Засаг даргын 2017 оны
06 дугаар сарын 15 өдрийн А/228
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

№	Зардлын зүйл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Журмын эмхтгэл	1000	7000	7.000.000